

"НИЙСЛЭЛИЙГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭГ"-ИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦ
(2025 оны жилийн эцсийн байдлаар)

2025 оны 12 дугаар сарын 01

Улаанбаатар хот

Д/д	Зорилт	Төсөл арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага	Эх үүсвэр	Суурь түвшин	Шалгуур үзүүлэлт, хэмжих нэгж	Зорилтот түвшин, үр пүнгийн үзүүлэлт	Батлагдсан төсөв (сая төгрөг)	Төсвийн гүйцэтгэл	Хэрэгжилтийн явц	Хэрэгжилтийн үнэлгээ
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13

ТАВ.ЗАСАГЛАЛ

80	5.3. Мэргэшсэн, чадварлаг, иргэндээ үйлчилдэг, тогтвортой төрийн албыг бэхжүүлж, төрийн үйлчилгээний үр дүн, үр нөлөөг дээшлүүлнэ.	5.3.1. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад болон олон улсын чанарын менежментийн тогтолцоо, стандартыг нэвтрүүлсэн байна.	2021-2025	НХСХГ, НЗДТГ	-	2022 оны 02 сар	Олон улсын чанарын менежментийн тогтолцоо "ISO9001:2016, MNS ISO 18091" стандартыг үйл ажиллагаанд нэвтрүүлж баталгаажуулалт хийгдсэн байгууллагын тоо	2021-2025 34	-	-	Хот байгуулалт, хот нийтийн аж ахуй, хүрээлэн буй орчны аюулгүй байдал, зохион байгууллагын чиглэлээр судалгаа хийх, стандарт норм дүрмийг боловсруулах, хэрэгжилтийг хангуулах, хянах, нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаа уялдааг холбоог сайжруулах хүрээнд чанарын менежментийн тогтолцоог MNS ISO 9001:2016 стандартын дагуу нэвтрүүлж SFCSS-ISO9001/2021-047 гэрчилгээг авсан. Дээрх ажлын хүрээнд тус байгууллагын 1 албан хаагч тэргүүлэх аудитор, 2 албан хаагч Дотоод аудиторын эрх авсан.	100%
----	--	---	-----------	--------------	---	-----------------	--	--------------	---	---	---	------

НАЙМ. БҮС, ОРОН НҮТГИЙН ХӨГЖИЛ

120	8.1.7. Улаанбаатар хотод сөрөг нөлөө үзүүлж байгаа үйлдвэр, аж ахуйн нэгжийг хотоос Шилжүүлэх бодлого боловсруулж, хэрэгжүүлж эхэлсэн байна.	2021-2025	НХБХГ, НМХГ, НЕБИХГ, ХСОАБХЭГ	2020 он 0	Боловсруулсан бодлогын бичиг баримт	2021-2025 1	<p>Нийслэлийн Хяналт шалгалтын газраас 2025 онд байгаль орчинд сөргөөр нөлөө үзүүлж буй дараах 3 үйлдвэр аж ахуйн нэгжийг хотоос нүүлгэн шилжүүлэх шийдвэрийг гаргуулсан. Үнд:1. БЗД-ийн 11-р хороонд байрлах "Ньюсевер" ХХК-ийн керамзитын үйлдвэрийг оршин суух бүсээс гаргах ажлыг зохион байгуулж, 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 02-13-01/039/382 дугаартай албан шаардлага хүргүүлж, Налайх дүүргийн үйлдвэрийн зөвшөөрсөн бүсрүү нүүлгэн шилжүүлсэн.</p> <p>2.ХУД-ийн 20 дугаар хороонд байрлах "Тэдмэнт бетон" зуурмагийн үйлдвэрт төлөвлөгөөт бүс хяналт шалгалт хийж, СХД-ийн 20-р хороонд зөвшөөрсөн бүс рүү нүүлгэн шилжүүлсэн.</p> <p>3.ХУД-ийн 3-р хороонд байрлах "Магнет Импорт" барилгын материалын хуурай холцыйн үйлдвэрийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт бүс хамтарсан хяналт шалгалт хийж, үйл ажиллагааг бүр мөсөн зогсоож, сууршгийн бүсээс нүүлгэн БГД-ийн 20-р хороонд үйлдвэрийн зөвшөөрсөн бүсэд шилжүүлэхээр шийдвэрлэсэн.</p>	100%
ЕС. УЛААНБААТАР БА ДАГУУЛ ХОТ								
Зорилго 9. Орон зайн оновчтой төлөвлөлтийн хүрээнд хотын төвлөрлийг задгалж орон сууц, дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлэн, хот байгуулалтын үйл ажиллагаанд ухаалаг технологийн шинэчлэл хийн								
139	9.5.3. Хотын стандартын дагуу орчны аюулгүй байдлын хяналт, шалгалтыг сайжруулж, иргэдийн	2021-2025	НОСК, НХСХГ, НХБХГ	2019	Хотын стандартын баримт бичиг	2021-2025 120	<p>Хотын стандартыг мөрдүүлэх арга хэмжээний хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэв.</p> <p>Үнд: 1. Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/237 дугаар захирамжийн хүрээнд нийтийн эзэмшлийн зам талбайд зөвшөөрөлгүй байршуулсан барилгын</p>	100%

		амьдрах орчны эрсдэлийг бууруулсан байна.							<p>өргөтгөл, шаардлага хангахгүй барилгын түр хашаа, түүц, хашаа, хайс, зөөврийн байгууламж, зар сурталчилгааны байгууламжуудад улсын байцаагчийн албан даалгавар 22, албан шаардлага 77, зөвлөмж 91, Торгууль 12, мэдэгдэх хуудас 1, шаардах хуудас 113 хүргүүлсэн. Мөн хяналт шалгалтын ажлын хүрээнд нийт 470 байршилд ажиллаж 290 зөрчил бүртгэлжүүлэн 99 зөрчлийг арилгуулсан.</p> <p>2. Хоёрдогч түүхий эд авах, тос тосолгооны материал худалдаалах,авто засвар, авто угаалга, дугуй засварын газруудад төлөвлөгөөт бус шалгалт хийх тухай удирдамжийн хүрээнд Сонгинохайрхан, Баянзүрх дүүрэгт үйл ажиллагаа явуулж буй нийт 49 байршилд хяналт шалгалт хийж, 45 байршилд шаардлагатай бичиг баримтыг тогтоосон хугацаанд шалгуулах тухай хугацаатай шаардах хуудас хүргүүлэн 4 байршилд тус дүүргийн Газар зохион байгуулалтын албанаас мэдэгдэх хуудас хүргүүлсэн.</p> <p>3. Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/214 дугаартай захирамжаар 2025 оны 02 дугаар сарын 18-ны өдрөөс 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн хооронд нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй 770 нийтийн байрны орчин, нөхцөл байдалд хяналт шалгалт хийж 7630 зөрчил илрүүлэн, 2334 зөвлөмж, 403 мэдэгдэл, 12 албан шаардлагыг тус тус хүргүүлсэн.</p> <p>4. Хяналт шалгалтын газрын даргын</p>	
--	--	---	--	--	--	--	--	--	--	--

									<p>А/47 дугаар тушаалаар урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх удирдамжийн хүрээнд нийслэлийн 9 дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй төрийн болон хувийн өмчийн 68 цэцэрлэг, 64 сургууль буюу нийт 132 объектын гадна болон дотоод орчны стандартын хэрэгжилт, барилгын ашиглалтын төлөв байдал, гадна талбайн тохижилт, явган хүний зам, гадна хаяг, хашаа, гадна шат довтоо, камержуулалт хөгжлийн бэрхшээлтэй иргэний хүртээмжтэй байдлын стандартын хэрэгжилтэд шалгалт хийж, нийт 654 зөрчил, дутагдлыг илрүүлж улсын байцаачийн "Стандартын хэрэгжилтийг хангуулах тухай" 132 зөвлөмж, 45 шаардах хуудсаар хугацаатай үүрэг даалгавар өгч ажилласан.</p>	100%
--	--	--	--	--	--	--	--	--	--	------

НИЙТ ХЭРЭГЖИЛТИЙН ХУВЬ

ХЯНАСАН:
 ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА
 Б.БАЙГДЛМАА

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН
 ДОТООД ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА
 Б.ОЮУНТУЯА



БИЕЛЭЛТ НЭЛТГЭСЭН:
 ЗАХИРГААНЫ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ, ХЯНАЛТ
 ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН
 Ч.АРИУНЖАРГАЛ